

2024 оны 01 дүгээр сарын ... -ны өдөр

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ЗОРИЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 он

Баруун-Урт сум

д/д	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажил	Төсөв	Хугацаа	Хариуцах нэгж	Биелэлт
1. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД					
Зорилт 1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцан ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах					
1.1	Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд зохион байгуулж байгаа /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах	Тухайн байгууллагууд хариуцана	4 дүгээр улиралд	а/д С.Батхуяг	
1.2	Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сүхбаатар , Эрдэнэцагаан, Асгат суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	Байгууллагын төсөв	3 дугаар улиралд	Урьдчилан сэргийлэх тасаг	
1.3	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдад гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургал зохион байгуулж мэдлэг олгох	Тухайн байгууллагууд хариуцана	Жилд	Урьдчилан сэргийлэх тасаг	
1.4	Олон Улсын болон сайн дурын байгуулагатай хамтран ажиллах	Хамтрөн ажиллах байгууллага	2, 4 дүгээр улиралд	Урьдчилан сэргийлэх тасаг	

Зорилт 2 Техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг сайжруулж бэлэн байдлыг дээшлүүлэх

2.1	Техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг сайжруулж бэлэн байдлыг дээшлүүлэх	Байгууллагын төсөв	2-4 дүгээр улирал	х/ч О.Баттуяа, Нэгжийн дарга нар	
2.2	Гамшгийн голомтонд үүрэг гүйцэтгэх тусгай зориулалтын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.	Байгууллагын төсөв	Жилд	а/д М.Доржготов	

Зорилт 3 Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт, ур чадварыг нэмэгдүүлэх

3.1	Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалтыг бүрдүүлэх, Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчий сургуульд хүний нөөцийн нөхөн хангалтыг бүрдүүлэх зорилгоор иргэдийг сонгон шалгаруулж сургах	Улсын төсөв	2,4 дүгээр улирал	х/ч Х.Жамъянсүрэн	
3.2	Ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлагыг зохион байгуулах	Байгууллагын төсөв	жилд	х/ч Х.Жамъянсүрэн, нэгжийн дарга нар	
3.3	Ахлагч нарын эрүүл мэндийг сайжруулах, эрүүлжүүлэх, биеийн зохистой харьцааг хангуулах	Байгууллагын төсөв	жилд	а/х Б.Батзориг, Нэгжийн дарга нар	
3.4	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахлагч нарын дунд нийтийн биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах	Байгууллагын төсөв	жилд	Газрын орон тооны бус ахлагчийн зөвлөл, Биеийн тамир спотын зөвөл	
3.5	Байгууллагын ахлагчийн бүрэлдэхүүний ажил, амьдралыг хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Байгууллагын төсөв	жилд	Газрын орон тооны бус ахлагчийн зөвлөл,	
3.6	Ахлагч бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд байгууллагаас дэмжлэг үзүүлэх	-	жилд	хур. Анхбаяр	

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЗОРИЛТ

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, эрүүл мэндийг дэмжиж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах

4.1	Офицер, ахлагч бүрэлдэхүүний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх олон улсын болон	Улсын төсөв	Жилд	х/ч Х.Жамъянсүрэн,	
-----	---	-------------	------	--------------------	--

	дотоодын дадлага сургуулалтанд хамруулах.			нэгжийн дарга нар	
4.2	Томилгоот бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангуулж, өдөр тутмын эрүүл мэндийн хяналтыг тогтмол хийх	Төсөв шаардлагагүй	өдөр бүр	а/х Б.Батзориг, дуудлага хүлээн авагч нар	
4.3	эм, эмнэлгийн хэрэгслийн нөхөн хангалтыг сайжруулж, эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангуулах	Улсын төсөв	Улирал бүр	а/х Б.Батзориг	
4.4	Алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийг дэмжиж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Улсын төсөв	Жилд	а/х Б.Батзориг	
4.5	Халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, эрүүл дадал хэвшил, төлөвшүүлэх	төсөв шаардлагагүй	Жилд	а/х Б.Батзориг	
4.6	Байгууллагын өрөө тасалгааны өнгө үзэмж, орчин нөхцөлийг сайжруулах	байгууллагын дотоод нөөц боломж	Жилд	а/х Б.Батзориг	
4.7	Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, бүтээмжийн зөвлөлийн төлөвлөгөө гаргаж хийж хэрэгжүүлэх	Байгууллагын болон төсөл, хуримтлалаас	Жилд	а/д М.Доржготов нэгжийн дарга нар	

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
 ХҮНИЙ НӨӨЦ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ ХАРИУЦСАН
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
 ХОШУУЧ

Х.ЖАМЪЯНСҮРЭН

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЗОРИЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 он

Баруун-Урт сум

д/д	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажил	Төсөв	Хугацаа	Арга хэмжээний хэрэгжилт	Биелэлтийн хувь
1. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД					
Зорилт 1 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын харилцан ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах					
1.1	Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангид гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах	Тухайн байгууллагууд хариуцана	4 дүгээр улиралд	Сүхбаатар аймгийн 13 сумын гамшиг хариуцсан мэргэжилтэн нарт 2025 оны 1 дүгээр сард Аймгийн хэмжээнд команд штабын сургууль болохтой холбогдуулан цахимаар онолын хичээл сургалт орж цагийн байдал өгч дадлагаар команд штабын сургалт зохион байгуулж 13 сумын тамгын дарга нар болон холбогдох мэргэжилтэн ажилтан, алба хаагч нарыг хамруулан зохион байгуулсан. Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд зохион байгуулж байгаа /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдлага, алба хаагчдад 2024 оны 11 сарын 11-ний өдрийн 05:00 цагт “Яаралтай цуглар” зарлан мэдээллийн дохиог өгч, бэлтгэл, бэлэн байдлыг шалгасан. Сургалтад 86 ажилтан, алба хаагч оролцсон	90
1.2	Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	Байгууллагын төсөв	3 дугаар улиралд	Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан. Сумдын мэргэжлийн ангийн 120 гаруй алба хаагч нар хамрагдсан. Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Эрдэнэцагаан суманд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 оны 04 дүгээр	100

				сарын 04-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд Онцгой байдлын газраас 5 алба хаагч, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын 18 албан хаагч, 5 автомашинтай түймэр гарах эрсдэлтэй Эрдэнэцагаан сумын Хөндлөн хайлааст , Хонгор, Бадрах, Жаргалант, Хадын булан багийн 230 малчин өрхийн 806 иргэнд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдал хангах, үнс нурмаа ил задгай газар асгахгүй байх талаар мэдээлэл хүргэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж брошур, гарын авлага тараан what3words аппликейшнийг гар утсанд нь суулган ажиллах зарчмын талаар мэдээлэл хүргэж, айл өрхийн 3-н үгт хаяг, утасны дугааруудыг бүртгэж, 1200 ширхэг тараах материал өгч ажилласан.	
1.3	Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан албан хаагчдад гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургал зохион байгуулж мэдлэг олгох	Тухайн байгууллагууд хариуцана	Жилд	Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу ангиллын сургалтыг 327 аж ахуйн нэгжид, байгууллагад нийт 434 цагийн сургалтаар “Гамшгаас хамгаалах тухай” хууль, “Галын аюулгүй байдлын тухай” хууль, холбогдох дүрэм, журам, “Гамшгаас хамгаалах Бэлэн бай” багц “What3words” хичээлүүдээр танхимын сургалт, гал унтраах дадлагыг Гал түймэр унтраах, аврах 15, 47 дугаар анги, Урьдчилан сэргийлэх тасаг хамтран нийт 13920 иргэнийг хамруулан сургалт зохион байгуулан ажилласан.	100
1.4	Олон Улсын болон сайн дурын байгуулагатай хамтран ажиллах	Хамтрөн ажиллах байгууллага	2, 4 дүгээр улиралд	Улсын Онцгой комисс, Японы Хүүхдийг Ивээх Сантай хамтран what3words буюу гурван үгт хаягийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх Know exactly where буюу яг хаана байгаагаа мэдэцгээе аяны хүрээнд төсөл хэрэгжиж байгаа Сүхбаатар, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль, Баруун-Урт сумын Мэргэжил сургалт	100

				үйлдвэрлэлийн төвийн оюутан, сурагчдад болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлагыг зохион байгуулан ажилласан. Аймгийн Улаан загалмайн хороотой хамтран “Өсвөрийн аврагч-2024” чадавхжуулах сургалт, дадлагыг Ерөнхий боловсролын сургуулийн Өсвөрийн аврагч бүлгэм, өсвөрийн Улаан загалмай идэвхтэн гишүүдийг хамруулан зохион байгуулсан.	
Зорилт 2 Техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг сайжруулж бэлэн байдлыг дээшлүүлэх					
2.1	Техник тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг сайжруулж бэлэн байдлыг дээшлүүлэхэд анхаарах, хариуцсан анги, салбар нэгжийн захирагч нар судалгаа гаргах биелэлтийг хангах	Байгууллагын төсөв	2-4 дүгээр улирал	Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 05 сарын 31 ны 208 дугаар тогтоолоор Ланд-76, шуурхай албаны автомашин, 190.000.000, Ковш дугуйт ачигч, Зил-131 автомашин хүлээн авч гамшиг аюулт үзэгдэлтэй тэмцэх чадавхаа нэмэгдүүлж бэлтгэл бэлэн байдлаа хангаж байна. Онцгой байдлын ерөнхий газрын Ар талын 115 дугаар ангиас батлагдсан хуваарийн дагуу алба хаагчдын хувцас, сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийг хүлээж авч байна. 2024 онд нормын хувцас хэрэглэл 93,182,393 төгрөг, сэлбэг хэрэгсэл 14,815,800 төгрөг, тусгай зориулалтын тоног төхөөрөмж 53,194,590 төгрөгийн бараа материалыг хүлээн авч данс бүртгэлд тусган ажилласан. Нийт алба хаагчдын 80% нь нормын хувцас хангалт шинээр авсан. Онцгой байдлын газрын даргын баталсан хуваарийн дагуу албан хаагчдад хувцас хэрэглэлийг олгож картын баяжилтыг тухай бүр хөтөлж алба хаагчид хувцас хүлээн авч гарын үсэг зуран баталгаажуулж байна	
2.2	Гамшгийн голомтонд үүрэг гүйцэтгэх тусгай зориулалтын техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.			2023-2024 онд Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн тусгай зориулалтын Ковш дугуйт ачигч 2ш Foton Iovol трактор, Зил-131 автомашинууд, сумд руу зам гаргах, түлээ нүүрс, өвс тэжээл хүргэх, суусан	100

				машин техник гаргах, шар усны үерт автсан айлыг гаргах, малын сэг зэм устгал 31 удаагийн дуудлагад нийт 3,702 км явж гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн. Тусгай зориулалтын автомашин техникийн бэлтгэл бэлэн байдлыг хангах засвар үйлчилгээгээр 8,060,000 төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулаад байна. Тэргүүн дэд даргын үүргийн хүрээнд хээрийн гал түймэр унтраах зориулалттай БМП-1 явган цэргийн байлдааны машиныг засварлаж бэлэн байдал хангасан.	
Зорилт 3 Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт, ур чадварыг нэмэгдүүлэх					
3.1	Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалтыг бүрдүүлэх, Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчий сургуульд хүний нөөцийн нөхөн хангалтыг бүрдүүлэх зорилгоор иргэдийг сонгон шалгаруулж сургах	-	2,4 дүгээр улирал	ДХИС-ийн Ахлагчийн сургуулийг төгсөн хүний нөөцөд бүртгэлтэй байсан дуудлага хүлээн авагч-1, аврагч, гал сөнөөгч-7, Гал унтраах автомашины жолооч 1, хүүхэд асрах чөлөөтэй алба хаагчийн орон тоонд түр ажилтнаар 2 нийт 11 алба хаагчийг сургаж томилуулах саналыг ОБЕГ-т хүргүүлж шийдвэрлүүлсэн. Мөн Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн мэргэжил олгох сургалтад хүний нөөц бүрдүүлэх зорилгоор 12 алба хаагчийг сургаж байна. Ахлагч бүрэлдэхүүний нөхөн хангалт 97.6% байна.	97
3.2	Ахлагч бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	-	жилд	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/324, А/310, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Густров хотноо “Аврагчийн өдөр”-т зориулсан “2024 Техникийн аврах ажиллагааны олон улсын сургалт” 1 алба хаагч, Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотод зохион байгуулагдсан Аврагч, гал сөнөөгч, ГУАМ жолооч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад 4, Хил орчмын ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хамтран ажиллах тухай 2022 онд баталсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах	100

				Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд ӨМӨЗО-ны Улаан хотод зохион байгуулагдсан Ой, хээрийн түймэр унтраах хамтарсан тактикийн дадлага сургалтад 6 алба хаагч, нийт 11 алба хаагч олон улсын чанартай сургалтад хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж ажилласан байна.	
3.3	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ахлагч нарын дунд нийтийн биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах	Байгууллагын төсвөөс	жилд	Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор зохион байгуулагдаж буй “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын зүүн бүсийн ахлагч нарын чуулга уулзалт”-аар зохион байгуулагдсан олс таталт, хөгжилтэй буухиа зэрэг тэмцээн уралдаан Онцгой байдлын газрын алба хаагчид амжилттай оролцож “Ахлагчийн өдөр”-ийг Баруун-Урт цэргийн хүрээний ахлагчийн зөвлөлөөс зохион байгуулсан соёл урлаг, спорт, сайн үйлсийн аянд Онцгой байдлын газрын Орон тооны бус ахлагчийн зөвлөл амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн	100
3.4	Байгууллагын ахлагчийн бүрэлдэхүүний ажил, амьдралыг хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	Байгууллагын төсвөөс	Жилд	Онцгой байдлын байгууллагын 20 жилийн ойн хүрээнд Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжил онцлогийн харуулсан өдөрлөг үйл ажиллагааг зохион байгуулж орон нутгийн болон ОБЕГ-тай хамтран Алба хаагчдын ажил мэргэжил онцлогийн харуулсан “Онцгой алба-бидний алба” гэр бүлийн уулзалт, зөвлөгөөн”, ОБЕГ-н даргын “Талархлын захидал”, ОБЕГ-аас эрхлэн гаргадаг “NEMA times” “Гэр бүл- Аз жаргалын эхэн” зэрэг нэвтрүүлэгт 5 алба хаагчийг оролцуулж ажилласан.	100
3.5	Ахлагч бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд байгууллагаас дэмжлэг үзүүлэх	-	Жилд	Эрдэнэцагаан сум дахь Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн алба хаагчдын орон сууцны асуудлыг сумын ИТХ-аар бүрэн шийдвэрлүүлж,	100

				байгууллагын нэр дээр данснаас дансанд шилжүүлэн авснаар өөр орон нутгаас томилогдон ажиллаж байгаа байгууллагын удирдлагууд, офицер, ахлагч болон түрээсийн байраар амьдарч байгаа алба хаагчид, залуу гэр бүлийг дэмжих зорилгоор албаны 8 айлын орон сууцанд 7 алба хаагчийг гэр бүлийн хамт, Эрдэнэцагаан сумын гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн албаны байранд гэр бүлийн хамт-2, гэр бүлгүй 8 , нийт 17 алба хаагчийг орон сууцаар хангаж нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллаж байна. Алба хаагчийн ар гэр лүү чиглэсэн эмчилгээ сувилгаа, асаргаанд зориулж 4 алба хаагчдад албанаас дэмжлэг тусламж үзүүлж ажилласан.	
Нийт дүн					98.5%
Онцгой байдлын газрын 2024 оны зорилт					
Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, эрүүл мэндийг дэмжиж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах					
1	Офицер, ахлагч бүрэлдэхүүний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх олон улсын болон дотоодын дадлага сургуулалтанд хамруулах.	Улсын төсөв	х/ч Х.Жамъянсүр эн	Холбооны Бүгд Найрамдах Герман Улст, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад олон улсын чанартай зохион байгуулагдсан сургалтад 11 алба хаагч хамрагдаж мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж ажилласан байна. Онцгой байдлын ерөнхий газар болон Бүсийн төв, орон нутагт төрөл мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдсан удирдах бүрэлдэхүүний болон алба хаагчдад богино хугацааны сургалтад давхардсан тоогоор 67 алба хаагч хамрагдсан байна.	100
2	Томилгоот бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангуулж, өдөр тутмын эрүүл мэндийн хяналтыг тогтмол хийх	Төсөв шаардлагагүй	өдөр бүр	Онцгой байдлын газар, гал түймэр унтраах аврах 15 дугаар анги, эрэн хайх, аврах салбарын томилгоот харуул ээлж болон эрүүл мэндийн тусламж шаардлагатай 470 алба хаагч, Эрдэнэцагаан сум дахь гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүнийг дуудлага хүлээн авагч нар өдөр бүр хяналт тавьж 780 алба хаагч, Түмэнцогт сум дахь эрэн хайх, аврах бүлгийн алба	100

				хаагчдыг аврагч, ахлагч С.Наран-Эрдэнэ хяналтын үзлэг тогтмол хийж 870 алба хаагч, нийт газрын хэмжээнд 2110 алба хаагчдад урьдчилан сэргийлэх, артерийн даралт, пульс хэмжих хяналтын үзлэгт хамруулсан. Үүнээс АД ихэссэн, идээт үрэвсэл гарсан, тулгуур эрхтэн гэмтсэн 6 алба хаагчийг жижүүрээс буулгаж, 1-р шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж, бэлтгэл ээлжийн алба хаагчийг ажиллуулж, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулсан.	
3.	Эм, эмнэлгийн хэрэгслийн нөхөн хангалтыг сайжруулж, эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангуулах	Улсын төсөв	Улирал бүр	Албаны бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн нөхөн хангалтыг батлагдсан төсвийн хүрээнд 18 нэр төрлийн 645.000 төгрөгийн худалдан авалт хийж, 144 дүгээр салбар, шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн эмийн санг 1 удаа, болон яаралтай тусламжийн цүнхний нөхөн хангалтыг 2 удаа хийсэн. Эрүүл мэндийн тусламж шаардлагатай 65 алба хаагчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлснээс 18 алба хаагч орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан. 10 алба хаагч дараагийн лавлагаа шатны эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.	90
4	Алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийг дэмжиж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Улсын төсөв	а/х Б.Батзориг	Цэргийн төв эмнэлгийн явуулын амбулаторийн эрт илрүүлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 96 алба хаагч буюу 81.3%-ийг хамруулж, үндсэн болон хавсарсан оношны улмаас эрүүл мэндийн арын мэргэжлийн эмч нарын хяналт, нарийвчилсан шинжилгээ, эмчилгээнд 15 алба хаагчийг хамруулаад байна. Мөн “Цусны даралт ихсэлтийн эсрэг” аяны хүрээнд Улсын 3-р төв эмнэлгийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 44 алба хаагч хамруулж, АД ихэсдэг 7	90

				алба хаагчийг шинжилгээнд хамруулсан. Онцгой Жаргалант сувилалд алба хаагчийг хөнгөлөлттэй үнээр хамруулах нөхцөлийн дагуу гал түймэр, гамшиг ослын дуудлага мэдээлэлд тогтмол ажилладаг нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа шаардлагатай 41 алба хаагч буюу нийт бие бүрэлдэхүүний 34.7%-ийг хамруулж эрүүлжүүлэх үйл ажиллагаанд давхардсан тоогоор 138 алба хаагчийг хамруулсан.	
5	Халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, эрүүл дадал хэвшил, төлөвшүүлэх	төсөв шаардлагагүй	Жилд	Тус газраас 2024 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд алба хаагчдыг халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Хачигт энцефалит”, “Тарваган тахал”, Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх” 3 удаагийн тарилгад давхардсан тоогоор 210 алба хаагч, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөөлийн АД ихсэлтийн аян, эрт илрүүлгийн үзлэг, сэтгэл зүйн сургалт, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 580 алба хаагчийг тус тус хамрууллаа. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/397 дугаар тушаал “Бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг батлах тухай” тушаалын хэрэгжилтийн хүрээнд хагас, бүтэн жилээр “Биеийн зохистой харьцаа”-ны үнэлгээг улирал тутам, бие бялдрын сорилыг сар бүр бүр авч, дүгнэж ажилласан. ОББ-ын 20 жилийн ой, гал сөнөөгчдийн баярт зориулсан спортын 3 төрөлт гэр бүлийн нөхөрсөг тэмцээн, “Илүүдэл жингүй-Эртэч Сүхбаатарчууд” өглөөний гүйлт, Баруун-Урт марафон гүйлт, байгууллагын аварга шалгаруулах үндэсний бөхийн барилдаан, цасны баяр, Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээний спортын олон төрөлтүүд зэрэг 6 арга хэмжээ, улс, аймаг, орон нутгийн	90

				хэмжээнд зохион байгуулсан 5 удаагийн тэмцээн, уралдаанд нийт давхардсан тоогоор 920 орчим алба хаагч, гэр бүлийн гишүүд, иргэд олон нийтийг хамруулж ажилласан.	
6	Байгууллагын өрөө тасалгааны өнгө үзэмж, орчин нөхцөлийг сайжруулах	байгууллагын дотоод нөөц боломж	Жилд	Байгууллагын өрөө, тасалгааны өнгө үзэмж сайжруулах ажлын хүрээнд дотоод нөөц боломжийг дайчлан ажиллуулж, алба хаагчдын 5 өрөө, 1, 2 дугаар давхрын коридорт иж бүрэн засвар, гал тогооны өрөөнд хэсэгчилсэн байдлаар засвар, харуулын байрны иж бүрэн засвар, 144-р салбарын засвар, гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн байрны засвар зэрэг ажлуудыг өөрсдийн нөөц боломжоор 11.348.000 төгрөг зарцуулж, орчин нөхцөлийг сайжруулсан.	100
7	Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, бүтээмжийн зөвлөлийн төлөвлөгөө гаргаж хийж хэрэгжүүлэх	Байгууллагын болон төсөл, хуримтлалаас	Жилд	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр байгууллагын зардал болон төсөл хөтөлбөр, алба хаагчдын хуримтлалаас нийт 14 төрлийн бүтээлч ажил хийж хэрэгжүүлж, нийт дүнгээр 84,245,600 төгрөг зарцуулж, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулан ажиллаж байна.	100
Нийт дүн					95.7%

ТАНИЛЦСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б.АНХБАЯР

ХЯНАСАН:
ГАЗРЫН ОРЛОГЧ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАСГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА С.ГАНБАТ

ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХОШУУЧ Х.ЖАМЪЯНСҮРЭН

